

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020.04.24

Улаанбаатар хот

Тус компанийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит Хурал, хурал хийхээр товлосон зарын дагуу 2020.04.24-ний өдрийн 14 цаг 00 минутад Компанийн хурлын танхимд болов.

Хурлыг ТУЗ-өөс томилсон хурлын дарга Лхагва овогтой Янжин нээж үг хэлэв.

Хурлын дарга Л.Янжин: “Коронавируст халдвар (Covid-19) цар тахлын улмаас олноор цугларах, хурал цуглаан зохион байгуулахыг хориглосон энэ нөхцөл байдал болон Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу энэ удаагийн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурал онлайн хэлбэрээр явагдаж байгаагаар онцлогтой байна. Хувьцаа эзэмшигч та бүхнийг хуралдаа идэвхитэй оролцохыг урьж байна” гэв.

Хурлын дэгийн дагуу хурал эхлэхээс өмнө Тооллогын Комисс Хувьцаа эзэмшигчдийн хуралд бүртгүүлж саналаа өгсөн хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэл, саналын эрхийн тоо, хурлын ирц, Тооллогын комиссын 2020.04.24-ний өдрийн “Хүчин төгөлдөрт тооцох тухай” №01 тоот тогтоолыг комиссын дарга Т.Болортуяа уншиж танилцуулав. /Уг тогтоолыг хурлын материалын .. хуудсанд хавсаргав/

Тооллогын комиссын дарга Т.Болортуяа: Хувьцаа эзэмшигчдийн Ээлжит Хуралд **3 800 721** ширхэг хувьцаа эзэмшиж буй **9 835** хувьцаа эзэмшигчдээс саналын эрх бүхий **2 633 361** ширхэг хувьцаа эзэмшсэн **333** хувьцаа эзэмшигч бүртгүүлж саналаа өгсөн байна. Энэ нь нийт хувьцааны **69,28** хувийг төлөөлж байна. Иймээс Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 1-д заасан заалтыг үндэслэн “Хурал хүчин төгөлдөрт тооцсугай” гэв.

Үүний дараа хурлын дэг, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Хурал даргалагч: Өнөөдрийн хурлаар:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг батлах
2. 2020 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох, гишүүдийн цалин болон 2020 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг батлах
4. Ногдол ашгийг нэгж хувьцаанд 120 төгрөгөөр хуваарилах асуудлыг хэлэлцэнэ гэсний дагуу хурлын дараалал ёсоор:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон компанийн 2020 оны төлөвлөгөөг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ж.Чинзориг илтгэв.
2. Компанийн 2019 оны санхүүгийн тайлан болон Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг компанийн ерөнхий нягтлан бодогч С.Батсүх тайлагнав.

Үүний дараа Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нэр дэвшигчдийн танилцуулга, 2020 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсөв, Төлөөлөн удирдах зөвлөлийн “Ногдол ашиг хуваарилах” тухай тогтоолыг танилцуулав.

Хурлын дарга Л.Янжин: 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг сонслоо. Одоо тайлантай холбоотой асуудал хариултандаа орёе. Хувьцаа эзэмшигчдээс ирсэн асуултанд холбогдох албан тушаалтан хариулна.

1. Хувьцаа эзэмшигч: Ганцэцэг

Нөөцийн мах хэр хэмжээтэй бэлтгэсэн бэ? Хаагуур зарагдаж байгаа вэ?

- Энэ жил Улсын нөөцөд хонь, үхэр, ямааны нийт 910 тонн мах бэлтгэсэн. Манай компанийн хувьд нөөцөд бэлтгэсэн мах нь гарал үүсэл тодорхой, чанар стандартын шаардлага хангасан сайн мах худалдаалж байгаа. Нөөцийн махыг Нийслэлийн захирагчийн ажлын албанаас хувиарлаж өгсөн дэлгүүрүүдтэй гэрээ хийн худалдаалж байгаа. СХД-т 10, СБД-т 3, ЧД-т 15 дэлгүүр, нэрийн барааны ТА-Чи мартын 6-н салбар дэлгүүрээр борлуулж байна. Нэг дэлгүүрт өдөрт дунджаар 300 кг мах тогтмол нийлүүлж байгаа, 7 дугаар сарын 15 хүртэл худалдаална. /Үйлдвэрийн дарга Н.Одгэрэл/

2. Хувьцаа эзэмшигч: Энхзаяа

Малчдыг дэмжих хөтөлбөр энэ жил хэзээнээс эхлэх вэ?

- Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд зохион байгуулж байгаа томоохон хөтөлбөрүүдийн нэг болох 2016онд эхэлсэн “Малчдыг дэмжих хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн зохион байгуулна. Энэ оны 7-р сараас эхлэх төлөвлөгөөтэй байгаа. /Үйлдвэрийн дарга Н.Одгэрэл/

3. Хувьцаа эзэмшигч: Баттөр

Коронавирусын нөхцөл байдал компанийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байна вэ?

- Манай компанийн хувьд коронавирус нь экспортын үйл ажиллагаанд нөлөөлж байна. 2019 оны сүүлийн сарууд 2020 оны эхний саруудад нийт 1000 тонн адууны мах БНХАУ-д экспортлохоор бэлтгэсэн боловч өнөөгийн нөхцөл байдлаас шалтгаалан экспорт хийх нь тодорхойгүй байна.

Мөн ИБНИУ-д 1000 тн төлөгний мах экспорплохоор төлөвлөсөн ч одоогийн байдлаар аланы байгууллагаас шийд гархыг хүлээж байна. /Үйлдвэрийн дарга Н.Одгэрэл/

4. Хувьцаа эзэмшигч: Уянга

2019 оны ноогдол ашигийг хэзээ өгөх вэ?

- 2019 оны ноогдол ашигийг энэ оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс компани дээр олгож эхлэнэ. /Үйлдвэрийн дарга Н.Одгэрэл/

5. Хувьцаа эзэмшигч: Жавдулам

Өмнөх онуудын ноогдол ашигийг нөхөн олгох уу?

- Өмнөх оны ноогдол ашигийг нөхөн олгоно. /Үйлдвэрийн дарга Н.Одгэрэл/

6. Хувьцаа эзэмшигч: Сугар

2019 онд ямар шинэ бүтээгдэхүүн гаргасан бэ?

- Бид 2019 онд 2 нэр төрлийн Хиама хиаман бүтээгдэхүүн, 5 нэр төрлийн Хагас боловсруулсан бүтээгдэхүүн дотоодын зах зээлд нэвтрүүлсэн. Мөн 2019 оны 4-р улиралд Хаан брэндийн хотдог, бургер, пицца гэсэн 3 нэр төрлийн бүтээгдэхүүн хэрэглэгчдэд хүргэхээр төлөвлөж энэ оны 3-р сараас худалдаанд гаргаж эхэлсэн. /Үйлдвэрийн дарга Н.Одгэрэл/

Хурлын дарга Л.Янжин: Өөр санал хүсэлт хэлэх хүн байна уу? Байхгүй бол санал шүүмжлэлээ таслах уу? Гэхэд бүгд зөвшөөрлөө. Та бүхний үнэтэй саналыг бид сонслоо, тэмдэглэлд тусгагдаж байгаа болно, хойшдын ажилдаа мөрдлөг болгоно, та бүгдэд баярлалаа. Одоо түр завсарлая, тооллогын комиссыг ажилдаа орохыг урья гэв.

Үүний дараа тооллогын комиссын дарга Т.Болортуяа "Саналын хуудсыг тоолж, дүнг танилцуулах тухай" тогтоолыг уншиж танилцуулав. /Уг тогтоолыг хурлын материалын .. хуудсанд хавсаргав/

Компанийн нийт **3 800 721** ширхэг хувьцаа эзэмшиж буй **9 835** хувьцаа эзэмшигчид хуралд саналын эрхтэй **2 633 361** хувьцаа эзэмшсэн **333** хувьцаа эзэмшигч оролцов. Тооллогын комиссоос тараасан саналын хуудас 333 ширхэг, хураан авсан саналын хуудас 333 ширхэг, асуулга тус бүрээс хүчингүй саналын тоо **34** буюу нийт саналын 10,21 хувь байна.

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлахыг зөвшөөрсөн **2 629 203** ширхэг хувьцаа, татгалзсан байхгүй, түтгэлзсэн байхгүй.
2. Компанийн 2020 оны бизнесийн төлөвлөгөөг батлахыг зөвшөөрсөн **2 629 203** ширхэг хувьцаа, татгалзсан байхгүй, түтгэлзсэн байхгүй.

ТУЗ-ийн ердийн гишүүнээр:

1. Ж.Чинзоригийг сонгохыг зөвшөөрсөн **3 598 539** ширхэг хувьцаа, татгалзсан 224 ширхэг хувьцаа, түтгэлзсэн 406 ширхэг хувьцаа.
2. Ж.Баттөрийг сонгохыг зөвшөөрсөн **3 598 378** ширхэг хувьцаа, татгалзсан 780 ширхэг хувьцаа, түтгэлзсэн 611 ширхэг хувьцаа.
3. Д.Цэнддоржийг сонгохыг зөвшөөрсөн **2 149 993** ширхэг хувьцаа, татгалзсан 705 ширхэг хувьцаа, түтгэлзсэн 611 ширхэг хувьцаа.

4. Х.Цэндбаярыг сонгохыг зөвшөөрсөн **2 144 808** ширхэг хувьцаа, татгалзсан 635 ширхэг, түтгэлзсэн 436 ширхэг.
5. Л.Янжинг сонгохыг зөвшөөрсөн **2 144 214** ширхэг хувьцаа, татгалзсан 696 ширхэг хувьцаа, түтгэлзсэн 9 ширхэг хувьцаа.
6. Д.Жанчивдоржийг сонгохыг зөвшөөрсөн **2 144 048** ширхэг хувьцаа, татгалзсан 611 ширхэг хувьцаа, түтгэлзсэн 307 ширхэг хувьцаа.

ТУЗ-ийн хараат бус гишүүнээр:

1. М.Баттогтохыг сонгохыг зөвшөөрсөн **2 141 477** ширхэг хувьцаа, татгалзсан 199 ширхэг хувьцаа, түтгэлзсэн 0 ширхэг хувьцаа.
2. Н.Лханчинбалыг сонгохыг зөвшөөрсөн **2 141 868** ширхэг хувьцаа, татгалзсан 46 ширхэг хувьцаа, түтгэлзсэн 0 ширхэг хувьцаа.
3. Ц.Цолмонг сонгохыг зөвшөөрсөн **2 139 045** ширхэг хувьцаа, татгалзсан 132 ширхэг хувьцаа, түтгэлзсэн 46 ширхэг хувьцаа.
4. Д.Даянбилгүүн сонгохыг зөвшөөрсөн **1 459 833** ширхэг хувьцаа, татгалзсан 49 ширхэг хувьцаа, түтгэлзсэн байхгүй.
5. Т.Однумыг сонгохыг зөвшөөрсөн **4 677** ширхэг хувьцаа, татгалзсан 10 ширхэг хувьцаа, түтгэлзсэн байхгүй.
3. 2020 оны ТУЗ-ийн зардлын төсвийг 5.670.000 төгрөгөөр батлахыг зөвшөөрсөн **2 629 203** ширхэг хувьцаа, татгалзсан байхгүй, түтгэлзсэн байхгүй.
4. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 120 төгрөгөөр хуваарилахыг зөвшөөрсөн **2 629 203** ширхэг хувьцаа, татгалзсан байхгүй, түтгэлзсэн байхгүй.

Дээрх хэлэлцсэн асуудлаар Хувьцаа эзэмшигчдийн Ээлжит Хурлын №01 тоот тогтоолыг гаргаж байна. Тогтоолыг уншиж танилцуулъя.


Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй.
2. Компанийн 2020 оны бизнесийн төлөвлөгөөг баталсугай.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны төсвийг 5.670.000 төгрөгөөр баталсугай.
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг компанийн дүрэмд зааснаар 3 жилийн хугацаатай сонгосугай.

5. Нэгж хугацаанд оногдох ногдол ашгийг 120 төгрөгөөр тогтоосугай.
гэж тогтоолыг уншиж танилцуулсанаар хурлын үйл ажиллагаа өндөрлөв.

Хурлыг хааж хурлын дарга Л.Янжин: "хуралд идэвхитэй оролцсон хувьцаа эзэмшигчдэдээ баярлалаа" гэв.

ХУРЛЫН ДАРГА



Л.ЯНЖИН

ТЭМДЭГЛЭСЭН



И.ӨЛЗИЙБАЯР

